

## ШҮГЭЛ ҮЛЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Зорилго

Энэхүү Премиум Нэксус ХК-ийн Шүгэл үлээх үйл ажиллагааны журам (“**Журам**”)-ыг Компани болон түүний охин болон хараат компани ( хамтад нь “**Компани**” гэх)-ийн ашиг сонирхол, ил тод байдал, шударга ёс, байгаль орчин, эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хангахын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, түүний нөхцөл байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 1.2. Хамрах хүрээ

Компанийн нийт ажилтан, ажиллагсад гэрээт ажилтан, бэлтгэн нийлүүлэгчид, бизнесийн түншүүд гэх мэт Компанийн үйл ажиллагаанд оролцогчид буюу Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх, эсхүл Компаниас нөлөөлөл авах магадлалтай талууд энэхүү Журмыг дагаж мөрдөнө.

#### 1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (“**БОНЗ Хороо**”) тухай бүр хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл энэхүү Журамд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

#### 1.4. Журмын нөхцөл

Энэхүү Журам нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэмд нийцсэн байна. Хэрэв Журам болон Компанийн Дүрмийн хооронд зөрүү гарвал Компанийн Дүрэм давуу үйлчилнэ. Мөн Журам нь хууль, тогтоомжтой нийцээгүй тохиолдолд тухайн хуулийн зохицуулалт нь давуу хүчинтэй байна. Энэхүү Журмын заалтыг хэрхэн тайлбарлах болон тэдгээрийг хэрэглэхтэй холбогдсон зарим тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн үед бусад ТУЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ. Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, Компанийн Дүрэм болон бусад эрх зүйн баримт бичгийн дагуу шийдвэрлэнэ.

#### 1.5. Нэр томьёо

Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.5.1. “**Ашиг сонирхлын зөрчил**” гэж эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудын хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил үүрэг болон Компанийн ашиг сонирхолтой зөрчилдөж, албан үүргээ зүй зохистой, шударгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;
- 1.5.2. “**Давуу байдал**” гэж Компанийн аливаа ажилтан, албан тушаалтан нь албан тушаалын эрх мэдлээ ашиглан, өөртөө эсхүл бусад Компани, хувь хүн, хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай нөхцөл бүрдүүлсэн байдлыг;
- 1.5.3. “**Компанийн ашиг сонирхол**” гэж Компанийн эрхэмлэх үнэт зүйлс, баримтлах зарчим, стратеги, бодлого, шийдвэр, дүрэм, журамд нийцсэн эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
- 1.5.4. “**Хамаарал бүхий этгээд**” гэж тухайн ажилтан, албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх, дүү, төрөл, садан, найз нөхөд болон бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;
- 1.5.5. “**Нэгдмэл сонирхолтой этгээд**” гэж тухайн ажилтан, албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

- 1.5.6. **“Хамгаалалтын арга хэмжээ”** гэж шүгэл үлээгчийн аюулгүй байдал, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн, энэ Журмын 7.2-т заасан арга хэмжээнүүдийг;
- 1.5.7. **“Хувийн ашиг сонирхол”** гэж эрх бүхий албан тушаалтан болон ажилтнууд нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;
- 1.5.8. **“Их хэмжээний хохирол”** Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Эрүүгийн хууль”-ийн дагуу тодорхойлсны дагуух хохирлын хэмжээг;
- 1.5.9. **“Ёс зүйн дүрэм”** гэж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдаж, тухай бүр өөрчлөлт орсон хүчин төгөлдөр дүрмийг;
- 1.5.10. **“Шүгэл үлээгч”** гэж энэ Журамд заасны дагуу Компанийн ашиг сонирхлын төлөө хууль бус болон зохисгүй үйлдлийн талаарх мэдээллийг өгсөн ажилтан, гэрээт ажилтан, албан тушаалтан, хувь хүн, эсхүл хуулийн этгээд болон тэдгээрийн төлөөлөгчийг;
- 1.5.11. **“Шүгэл үлээх”** гэж Компанийн ашиг сонирхлыг хохироосон, буюу хохироож болзошгүй үйлдэл, нөхцөл байдал, хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн байдал, илт тод байдал, шударга ёс, авлига хээл хахууль, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл өгөх, өргөдөл, гомдол гаргах, тайлбар гаргах (**“Мэдээлэл өгөх”**)-ийг тус тус ойлгоно.

## **2. ШҮГЭЛ ҮЛЭЭХ**

- 2.1. Шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 2.1.1. Монгол Улсад мөрдөгдөж буй хүний хувийн мэдээллийг хамгаалах, цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомжийг чанд мөрдөх;
  - 2.1.2. Хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
  - 2.1.3. Шүгэл үлээгчийн мэдээлэл болон хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, ажлын байрыг хамгаалах;
  - 2.1.4. Шүгэл үлээгчтэй хамтран ажиллаж, мэдээллийн үнэн зөвийг шалгах, нөхцөл байдлыг тодруулах ажиллагааг хамтын ажиллагаанд үндэслэх;
  - 2.1.5. Шүгэл үлээх боломжийг хангах хүртээмжтэй, найдвартай, аюулгүй сувгийг бий болгох;
  - 2.1.6. Шүгэл үлээсэн мэдээллийг үндэслэн зөрчлийг засах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
  - 2.1.7. Компанийн ашиг сонирхлын төлөө оруулж байгаа шүгэл үлээгчийн хувь нэмрийг цаг алдалгүй үнэлэх, урамшуулах.
- 2.2. Шүгэл үлээгч нь Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж, мэдээллийг бичгээр буюу цахим хэлбэрээр ирүүлнэ. Мэдээлэл нь тодорхой баримтаар баталгаажсан байна.
- 2.3. Шүгэл үлээгч нь энэ Журмын 1.5.9-д заасан мэдээллийг өгөхтэй холбоотой шүгэл үлээх ба дараах зөрчлийн талаар мэдээлэл гаргаж болно. Үүнд:
  - 2.3.1. Компанийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүй;
  - 2.3.2. Гэмт хэргийн шинж чанартай хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй;
  - 2.3.3. Мөнгө угаалт, татвараас зайлсхийх, хүний хувийн мэдээлэл болон бизнесийн мэдээллийг хууль бусаар задруулах зэрэг хууль зөрчсөн үйлдэл;
  - 2.3.4. Ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй үйлдэл, үйл

- ажиллагаа;
- 2.3.5. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх болон эрсдэл үүсгэх үйлдэл, үйл ажиллагаа;
- 2.3.6. Шударга бус, хууль зөрчсөн байдлыг хүлээн зөвшөөрч, эвлэрсэн үйлдэл, үйл ажиллагаа;
- 2.3.7. Компани Монгол Улсад мөрдөгдөж хууль дүрэм зөрчсөн шийдвэр гаргах, үйлдэл, үйл ажиллагаа явуулах;
- 2.3.8. Хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, бэлтгэн нийлүүлэгчийн сүлжээнд хамаарах ёс зүйгүй үйлдэл;
- 2.3.9. Эрх бүхий албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашигласан, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгосон үйлдэл болон авлига хээл хахууль, ашиг сонирхлын зөрчилтэй үйлдэл.
- 2.3.10. Гэрээт ажилтан, бэлтгэн нийлүүлэгчид, бизнесийн түншүүд нь Компанийн ажилтан, албан тушаалтанд аливаа авлига, хээл хахууль санал болгосон, санал болгохоор завдсан үйлдэл болон
- 2.3.11. Дээрхтэй адилтгах шинж чанар бүхий бусад үйлдэл болон эс үйлдэхүй;
- 2.4. Шүгэл үлээх журмын хүрээнд хувийн шинж чанартай хувь хүмүүсийн болон Компани хувь хүн хоорондын маргаан, үл ойлголцол, зөрчлүүд хамаарахгүй.
- 2.5. Шүгэл үлээх мэдээлэлд дараах агуулгыг дурдсан байна. Үүнд:
- 2.5.1. Энэхүү журмын 2.3-д заасан зөрчлийг үйлдсэн, эс үйлдэхүй, эсхүл оролцсон этгээдийн нэр, албан тушаал;
- 2.5.2. Зөрчилтэй холбоотой үйлдэл, эс үйлдэхүйн нөхцөл байдал, үйлдлийн тухай дэлгэрэнгүй тайлбар, түүнд холбогдох нотлох баримт;
- 2.5.3. Шүгэл үлээгчийн холбоо барих мэдээлэл.
- 2.6. Шүгэл үлээгч нь мэдээлэл өгөхдөө энэ Журмын 2.5.3-д заасан өөрийн мэдээллийг нууцлах эсэх талаар тодорхой дурдсан байна. Нууцлалыг хүссэн тохиолдолд Компанийн зүгээс уг мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 2.7. Шүгэл үлээгч нь энэ Журмын 2.5.3-д заасан өөрийн мэдээллийг ил болгохгүйгээр өөрийн төлөөлөгчөөр дамжуулан өөрийн нэрийн өмнөөс Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээж, мэдээлэл гаргаж болно.
- 2.8. Энэ Журмын 2.7-д зааснаар мэдээлэл гаргах тохиолдолд төлөөлөгч өөрийн нэр, холбоо барих утасны дугаарын мэдээллийг шүгэл үлээгчийн нэрийн өмнөөс шүгэл үлээх мэдээлэлд дурдсан байна.
- 2.9. Шүгэл үлээгч нь өөрийн мэдээллийг ил болгохгүйгээр Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх болсон үндэслэл, өөрийн хувийн мэдээллийг агуулсан захидлыг шүгэл үлээх мэдээлэлд хавсаргаж болох бөгөөд мэдээлэл болон захидлыг Ёс зүйн хороо хүлээн авч хадгалах ба аливаа бусад этгээдэд шүгэл үлээгчийн захидал, мэдээллийг задруулахыг хориглоно.
- 3. МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, БҮРТГЭХ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ**
- 3.1. Шүгэл үлээгч энэ Журмын 2.3-д заасан мэдээллийг энэ Журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу Ёс зүйн хороонд [www.cumongol.mn/whistleblow](http://www.cumongol.mn/whistleblow) шүгэл хүлээн авах цахим хуудсаар хүргүүлнэ.
- 3.2. Цахим хуудсаар дамжуулан авах шүгэл үлээгчийн ирүүлсэн мэдээллийг Ёс зүйн хороо хүлээн авна.
- 3.3. Ёс зүйн хороо нь ирүүлсэн мэдээллийг үнэлж, шаардлагатай тохиолдолд дараах нэмэлт

мэдээллийг шүгэл үлээгчээс нэмж тодруулж болно. Үүнд:

- 3.3.1. Энэ Журмын 2.5.2-т заасан мэдээллийг ирүүлээгүй эсхүл, хангалтгүй гэж үзвэл тодруулах;
- 3.3.2. Шүгэл үлээсэн мэдээлэл нь Компанийн ашиг сонирхлын төлөө гэж үзэх үндэслэл, зорилго.
- 3.4. Ёс зүйн хороо нь мэдээллийн дагуу Компанийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй үйлдэл, эс үйлдэл хийсэн эсэхэд холбогдох хяналт шалгалт явуулж, шалгалтын үр дүнг шүгэл үлээгчид даруй мэдэгдэх бөгөөд шүгэл үлээгч нь шалгалтын үр дүнг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ талаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд гомдол гаргаж болно.
- 3.5. Ёс зүйн хороо нь дараах тохиолдолд мэдээлэлд хяналт шалгалт явуулахгүй. Үүнд:
  - 3.5.1. Илт худал, санаатайгаар гүтгэсэн мэдээллээр шүгэл үлээсэн;
  - 3.5.2. Өмнө нь шалгагдаж, шийдвэр гарсан, тухайн үр дүнг нь шүгэл мэдэгдсэн асуудлаар шүгэл үлээсэн;
  - 3.5.3. Нотлох баримтгүй, үндэслэлгүй мэдээлэл өгсөн;
  - 3.5.4. Шүгэл үлээсэн мэдээллийг хүлээж авахаас өмнө Компанийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл үүсгэсэн үйлдэл, эс үйлдлийг хянан шалгах ажиллагаа явуулж эхэлсэн, эсхүл хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон; эсвэл
  - 3.5.5. Журмын 2.4 -д заасан болон хориглосон асуудлаар шүгэл үлээсэн.
- 3.6. Ёс зүйн хороо нь шүгэл үлээсэн мэдээллийг хянаж шалгахгүй байх талаар шүгэл үлээгчид үндэслэл бүхий хариу өгөх үүрэгтэй.
- 3.7. Өмнө нь шалгасан, үр дүнг нь мэдэгдсэн асуудлын талаарх Ёс зүйн хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд энэ Журмын 3.5.2-т заасан үндэслэл гэж үзэхгүй бөгөөд дахин хянаж үзэх боломжтой байна.
- 3.8. Ёс зүйн хороо нь Компанийн эрх ашиг ноцтой хөндөгдөх тохиолдол болон бусад шаардлагатай тохиолдолд Шүгэл үлээгчтэй хамтран ажиллах саналыг тавина. Шүгэл үлээгчийн нууцлалыг бүрэн хангах тохиролцоотойгоор энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

#### **4. ШҮГЭЛ ҮЛЭЭГЧ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- 4.1. Шүгэл үлээгч нь Компанийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл өгсөнтэй холбоотойгоор өс хонзон, ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, бие махбод болон сэтгэл санааны хохирол, хохирол учруулж болзошгүй аливаа хэлбэрийн үйлдлээс ангид байх эрхтэй ба Компани энэ эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 4.2. Шүгэл үлээгч болон түүний төлөөлөгч нь өөрийн хувийн мэдээллээ бусдад ил болгох зөвшөөрөл олгосон, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд түүний мэдээллийг нууцалж, шүгэл үлээгчийг тодорхойлох боломжгүй байх үндэсийг Компанийн зүгээс хангана.
- 4.3. Шүгэл үлээгч болон түүний төлөөлөгч нь хувийн мэдээллийг Журмын 4.2-т зааснаас бусад үндэслэлээр задруулсан бол үзвэл шүгэл үлээгч нь Төлөөлөн удирдах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.
- 4.4. Шүгэл үлээгч, болон түүний төлөөлөгч нь өөрсдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор, энэ Журмын 7.2-т заасан хамгаалалтын арга хэмжээ болон шаардлагатай бусад арга хэмжээ авахыг Ёс зүйн хорооноос шаардах эрхтэй.
- 4.5. Шүгэл үлээгч энэ Журмын 7.4.6-д заасан зөвлөгөөг авах тухай хүсэлтээ Ёс зүйн хороонд гаргах бөгөөд Ёс зүйн хороо нь хүсэлтийн дагуу шаардлагатай арга хэмжээ авна.

- 4.6. Шүгэл үлээгч хууль зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө авсан тухай нууцлахыг хүссэн тохиолдолд Ёс зүйн хороо нууцлах үүрэг хүлээнэ.
- 4.7. Шүгэл үлээгчийг эрхээ хэрэгжүүлэх, түүний хүсэлтээр хамгаалалтын арга хэмжээ авахад саад учруулсан аливаа хэлцэл, тохиролцоо, хөдөлмөрийн дотоод журмын холбогдох хэсгийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.
- 4.8. Шүгэл үлээгч Ёс зүйн хороонд мэдээлэл өгсөн асуудлаар ТУЗ-ийн БОНЗ хороонд хандаж болно.

## **5. ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД ХОХИРОЛ УЧРУУЛАХ ҮЙЛДЛИЙГ ХОРИГЛОХ**

- 5.1. Шүгэл үлээгчид шүгэл үлээсэнтэй холбоотойгоор хохирол учруулах, хохирол учруулж болзошгүй дараах үйлдлийг хориглоно. Үүнд:
  - 5.1.1. Шүгэл үлээсэнтэй холбогдуулан албан тушаалыг нь бууруулах, албан тушаал дэвших боломжийг хязгаарлах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас халах, өөрийн хүсэлтээр чөлөөлөхийг шаардах;
  - 5.1.2. Шүгэл үлээгчийн зөвшөөрөлгүйгээр албан үүрэг, ажлын байр, нэгж, чиг үүргийг өөрчлөх, шилжүүлэх;
  - 5.1.3. Цалин хөлс бууруулах, ажлын үр дүнгийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх, шагнал, урамшуулал олгоход ялгаварлан гадуурхах; эсвэл
  - 5.1.4. Шүгэл үлээгчийн ажилд хууль бусаар хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын үр дүнг ил болгох.
- 5.2. Хэрэв шүгэл үлээгч нь дээр дурдсан хориглосон аливаа үйлдэлд өртсөн гэж үзвэл, Ёс зүйн хороонд гомдол гаргах эрхтэй .
- 5.3. Энэ Журмын 5.1-д заасан аливаа арга хэмжээг авсан этгээд нь тухайн шийдвэрийн үндэслэл, шаардлагыг нотлох үүрэгтэй.
- 5.4. Шийдвэрийн үндэслэл нь нотлогдоогүй, эсхүл зохих хууль, компанийн дотоод дүрэм, журмыг зөрчсөн болох нь тогтоогдсон тохиолдолд шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг дордуулсан үйлдлийг зогсоож, учруулсан хохирлыг барагдуулж, энэ талаарх мэдээллийг ТУЗ-д хүргүүлнэ.

## **6. ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ХАРИУЦЛАГА**

- 6.1. Шүгэл үлээгч нь Компанийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл гаргахдаа тухайн мэдээлэл нь Компанийн эсхүл хувь хүний нууцын шинжтэй мэдээллийг агуулсан бол шүгэл үлээгчийг хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль, журамд заасан ажил мэргэжлийн хүрээнд нууц хадгалах үүргээ зөрчсөн гэж үзэхгүй.
- 6.2. Шүгэл үлээгчийн өгсөн мэдээлэл нь шалгалтын үр дүнд, Компанийн ашиг сонирхолд хамаарахгүй болохыг тогтоосон, бусад хууль, журам зөрчөөгүй гэж дүгнэгдсэн бол шүгэл үлээгчийг мэдээлэл өгсөнтэй нь холбогдуулан аливаа хариуцлагад татах үндэслэл болохгүй.
- 6.3. Дараах тохиолдолд шүгэл үлээгчид холбогдох хууль, дүрэм журамд заасан хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:
  - 6.3.1. Мэдээллийг шалгах явцад мэдээллийн нууцыг санаатайгаар задруулсан, эсвэл илт худал мэдээллийг бусдад тараасан;
  - 6.3.2. Өөртөө болон өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал бий болгох зорилгоор шүгэл үлээж, бусдын нэр төр, алдар хүнд, Компанийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг тараасан.

## **7. ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ**

- 7.1. Шүгэл үлээгч нь Компанийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл гаргасантай холбоотойгоор өөрт

нь болон түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөөнд халдсан, эсхүл халдаж болзошгүй эрсдэл үүссэн тохиолдолд Ёс зүйн хороонд хамгаалалтын арга хэмжээ авах талаар хүсэлт гаргах эрхтэй.

7.2. Компанийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй үйлдэл, зөрчлийн талаар мэдээлэл өгсөн шүгэл үлээгчийн хүсэлтийг үндэслэн дараах хамгаалалтын арга хэмжээг авч болно. Үүнд:

- 7.2.1. Хохирол учруулж болзошгүй тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 7.2.2. Шүгэл үлээхтэй холбоотой бүх мэдээллийн нууцлалыг чанд хадгалах;
- 7.2.3. Шүгэл үлээгчийн нэр, албан тушаал, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
- 7.2.4. Нэрээ нууцалсан шүгэл үлээгчийн талаарх мэдээ, мэдээллийг цуглуулах, задруулах, олж мэдэх үйлдлийг хориглох;
- 7.2.5. Хамгаалалт шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, шүгэл үлээгчид зохиомол нэр хэрэглэж, хамгаалалт үзүүлэх.

7.3. Ёс зүйн хороо нь дараах тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ авахаас татгалзаж болно. Үүнд:

- 7.3.1. Хамгаалуулах хүсэлтийг шүгэл үлээгч, эсхүл түүний төлөөлөгчөөс бусад хүн гаргасан;
- 7.3.2. Журмын 3.5-д заасан шалгах үндэслэлгүй нөхцөл үүссэн;
- 7.3.3. Өмнө нь цуцлагдсан хамгаалалтын арга хэмжээний талаар өөрчлөгдөөгүй нөхцөлөөр дахин хүсэлт гаргасан.

7.4. Ёс зүйн хороо нь шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 7.4.1. Шүгэл үлээсэн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;
- 7.4.2. Шүгэл үлээсэн мэдээллийн дагуу холбогдох этгээдтэй хамтран ажиллах;
- 7.4.3. Шүгэл үлээгч эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалалтын арга хэмжээ зохион байгуулах;
- 7.4.4. Шүгэл үлээгчид урамшуулал олгох үндэслэлийг хянаж шийдвэрлэх;
- 7.4.5. Шүгэл үлээгчийг хүлээн зөвшөөрөх, дэмжих, шүгэл үлээх мэдээллийг хэрхэн өгөх, авах, түүнийг шийдвэрлэхтэй холбоотой сургалт явуулах;
- 7.4.6. Шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах.

## **8. МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ**

8.1. Ёс зүйн хороо нь Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн мэдээллийг хүлээн авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, хянан шалгасан, шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авсан, цуцалсан, урамшуулал олгосон тухай мэдээллийг агуулсан Мэдээллийн нэгдсэн сантай байна.

8.2. Мэдээллийн санг энэ Журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу бүрдүүлж ашиглах ба аюулгүй байдлыг хангана.

8.3. Ёс зүйн хороо нь Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн талаарх мэдээллийг Компанийн хэмжээнд нэгтгэн гаргаж, дараа оны эхний улиралд багтаан ТУЗ-д мэдээлнэ.

## **9. БУСАД**

**9.1. Урамшуулал олгох**

- 9.1.1. Шүгэл үлээгчийн мэдээлэл нь нотлох баримтаар тогтоогдсон, үнэн зөв болох нь батлагдсан тохиолдолд Шүгэл үлээгчийг заавал урамшуулах зарчмыг баримтлан ажиллана.
- 9.1.2. Энэхүү журмын дагуу Урамшуулал олгох асуудлыг Ёс зүйн хороо тусгайлан хэлэлцэж, ТУЗ-д танилцуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Компанийн зүгээс шүгэл үлээгчид олгох урамшууллыг адил үндэслэлээр давхардуулан олгох болон нэг төрлийн зөрчилд давхардуулан олгохыг тус тус хориглоно.
- 9.1.3. ТУЗ урамшууллын асуудлыг хэлэлцэхдээ дараах нөхцөлийг харгалзан үзнэ. Үүнд:
- a. Шүгэл үлээгчийн ил болгосон мэдээлэл нь Компанийг их хэмжээний болон үүнээс дээш хэмжээний хохиролд өртөх, хууль зөрчих, мөнгөн дүнгээр тодорхойлох боломжгүй хохирол, компанийн нэр хүндийн эрсдэл зэрэг эдгээртэй адилтгах томоохон хэмжээний бусад эрсдэлээс сэргийлсэн тохиолдолд тухайн шүгэл үлээгчид мөнгөн урамшуулал олгох боломжтой байна.
  - b. 9.3.1-т заасан тохиолдолд хамаарахгүй нөхцөл байдал бий болсон бол шүгэл үлээгчид мөнгөн бус урамшуулал олгоно.
  - c. Шүгэл үлээгч нь Компанийн ажилтан, албан тушаалтан биш тохиолдолд тухайн шүгэл үлээгчийн нөхцөл байдлаас шалтгаалан, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

**9.2. Хориглох заалт**

- 9.2.1. Шүгэл үлээгч нь өөрт болон өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олж авах зорилгоор шүгэл үлээхийг хориглоно.
- 9.2.2. Шүгэл үлээгч нь бусдын нэр төр, алдар хүнд, Компанийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллээр шүгэл үлээхийг хориглоно.
- 9.2.3. Компанийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд саад хийх, шүгэл үлээгчийг мэдээллээ татаж авахыг хүчээр тулгахыг хориглоно.
- 9.3. Энэ Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль болон Компанийн хөдөлмөрийн дотоод журам, ажилтантай байгуулсан гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 9.4. Энэ Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол эрх бүхий байгууллагад мэдээлэн Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### Хавсралт 1.

#### Шүгэл үлээх мэдээлэл

Зөрчлийн төрөл:	
Компанийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй эс үйлдэхүй, үйлдэл хийсэн этгээдийн нэр, албан тушаал:	
Компанийн ашиг сонирхлыг хохироосон, эсхүл хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн тухай тайлбар:	
Холбогдох нотлох баримт (дүрс бичлэг, зураг, бичлэг, дуу бичлэг, харилцсан цахим шуудан, чат, захианы зураг г.м.):	

#### Шүгэл үлээгчийн мэдээлэл

Овог:	Харьяа компани:
Нэр:	Албан тушаал:
Утас:	Цахим шуудан:
Шүгэл үлээгчийн мэдээллийг нууцлах эсэх:	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Та өөрийн төөлөгдөгчөөр дамжуулан мэдээлэл өгөх эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй
Тийм бол төлөөлөгчийн нэр, холбоо барих мэдээлэл	

Шүгэл үлээгчийн нэр:

Он сар өдөр:

---

#### ЁС ЗҮЙН ХОРООНЫ ШИЙДВЭР

--

Ёс зүйн хорооны дарга:

Ёс зүйн хорооны гишүүд:

Он, сар, өдөр